


‘Яагаад’ гэдгээ мэдэж байвал илүү аюулгүй ажиллана

2025.04



1-р зураг. Хаалтны удирдлага (шифр), түүнийг тогтоосон эргүүд



2-р зураг. Хаалтны даралт барих тагны эрэг, шүргүүд



3-р зураг. Осол болсны дараа хаалтны харагдах байдал

2021 онд Техас мужийн Ла Порте хотод түншлэгч байгууллагын гурван ажилтан холбогч хаалтнаас удирдлагыг (шифрийг) нь салгаж авч байсан. Удирдлагыг нь салгаж авснаар шугам хоолойд засвар хийх үед тусгаарлах тоноглол болгон ашиглах боломжтой болох байсан. Удирдлагыг нь салгаж авсны дараа хаалтны даралт барих эд ангийг нь санамсаргүй салгаснаас болж даралтын нөлөөгөөр хаалтны гол нь их биеэсээ мултарч шидэгдсэн. 164,000 фунт (74,545 кг) орчим мөсөн цууны хүчил, метил иодидын идэмхий хорт шингэн хаалтны их биеэр хяналтгүй алдагдсан. Гэрээт байгууллагын гурван ажилтан руу шингэн цацагдсан. Хоёр ажилтан амиа алдаж, нэг ажилтан нь хариу арга хэмжээ авсан өөр нэг үндсэн ажилтны хамтаар ноцтой гэмтсэн. 29 хүнийг эмнэлэгт хүргэж оношилгоо болон эмчилгээ хийлгэсэн. (CSB 2021-05-I-TX тайланг харна уу)

2016 онд Луйзиана мужийн Батон Роуг хотод үүнтэй төстэй осол болсон. Ослын улмаас изобутан алдагдаж, гал авалцан шатсанаар дөрвөн ажилтан ноцтой түлэгдсэн. (CSB 2016-02-I-LA тайлан, 2021 оны 12 сарын CCPS мэдээллийг харна уу).

Эдгээр ослууд гурван ижил хүчин зүйлээс шалтгаалсан:

1. Үндсэн болон түншлэгч байгууллагын ажилчид, операторуудад хаалтны удирдлагыг салгаж авах тогтсон журам байгаагүй.
2. Үндсэн болон түншлэгч байгууллагын ажилчид, операторууд хаалтны удирдлагыг салгаж авахад сургагдаагүй.
3. Хаалтны удирдлагыг салгаж авахад ойр хавьд нь өөр ажилтнууд байж, тусалж байсан, тэд бүрүү эрэг, шүргийг салгаж байгааг хэлж сануулах боломжтой байсан.

Та мэдэх үү?

- Бүх чухал ажилд тухайн ажлыг гүйцэтгэх журам байх ёстой.
- Ашиглалтын болон Засвар үйлчилгээний журам боловсруулах, тэдгээр журмууд нь ашиглах хүмүүстэй ойлгомжтой байх.
- Чухал ажил гүйцэтгэх хүмүүс нь тухайн ажлыг гүйцэтгэх журмыг ажил гүйцэтгэж байх үедээ бэлэн байлгах.
- Сургалтад хамрагдсан хүмүүс сургалтыг ойлгосон, ажлыг зөв гүйцэтгэх чадвартай болсон гэдгээ нотлон харуулдаг байх шаардлагыг сургалтын үйл ажиллагаанд тусгах.
- Ажлыг зөв гүйцэтгэх магадлалыг сайжруулахын тулд сургалтад хамрагдсан хүмүүс журмыг заасан дэс дарааллын дагуу нэг бүрчлэн хэрэгжүүлэх нь яагаад чухал болохыг ойлгосон байх.

Та юу хийх ёстой вэ?

- Журам байхгүй бол АЖЛАА ЗОГСООЖ, уг ажлыг яавал аюулгүй хийж гүйцэтгэх талаар нягтлан хэлэлцэх.
- Аюултай, чухал ажлын журмыг боловсруулах, хянахдаа эрсдэлтэй үндсэн хүчин зүйлсийг тодруулсан зураг, диаграмм ашиглах.
- Гарын үсэг зурах шалгах хуудас ашиглавал журмыг илүү үр дүнтэй болгоно.
- Заавар ойлгомжгүй байвал ахлах ажилтнаасаа асууж тодруулж байх.
- Сургалтын үеэр асуулт асууж, энэ ажлыг яагаад заасан дэс дарааллын дагуу нэг бүрчлэн хэрэгжүүлэх шаардлагатайг ойлгож авах.
- Сургалт хийхдээ чухал ажлыг хэрхэн гүйцэтгэх, яагаад ингэж гүйцэтгэх ёстойг цаг гарган нарийн тайлбарлаж, асуултуудад тэвчээртэй, дэлгэрэнгүй хариулах.
- Журмыг хянах, өөрчлөх үед ажлын талбай дээр биеллэн очиж, журамд заасан зүйлс ажлын талбайн нөхцөл байдалтай тохирч байгаа эсэхийг шалгах.

Сургалт + Журам + ‘Яагаад’ гэдгийг ойлгох = Амжилт